



**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН-ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г

Г

Гишүүнчлэлийн хураамж тогтоох тухай

“Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 7.4 дэх заалт, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүдээс ирсэн саналыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн гишүүн байгууллага, гишүүн хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамжийн хэмжээг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.

Гурав.Энэхүү тушаалыг 2015 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.



Л.ГАНТӨМӨР

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн даргын 2015 оны 1 дүгээр сарын 21 ний өдрийн дүгээр тушаалын хавсралт



ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, ГИШҮҮН ХУВЬ ХҮНИЙ  
ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖИЛИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Нэг. Гишүүн байгууллага

д.д	Гишүүний төрөл		Хураамж
1	Хүндэт гишүүн	Үндэсний зөвлөлийн бүртгэлд бүртгэгдсэн гадаадын болон олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага хүндэт гишүүнээр элсэнэ.	500\$
2	Дэмжигч гишүүн	Үндэсний зөвлөл нь эрхэм зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахад тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг төр болон хувийн хэвшил, төрийн бус, олон нийтийн байгууллага нь дэмжигч гишүүнээр элсэнэ.	300000,0 төгрөг
3	Үндсэн гишүүн	Үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн сургууль нь үндсэн гишүүнээр шууд бүртгэгдэнэ. 1000 хүртэл суралцагчтай бол 1001-ээс дээш суралцагчтай бол <i>Тайлбар: Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж доторх бүрэлдэхүүн болон салбар сургууль тус бүрийг нэг нэгж гэж үзэн дээрх хураамжийг суралцагчийн тооноос хамааран тусад нь төлнө.</i>	1000000,0 төгрөг 2000000,0 төгрөг
4	Дэд гишүүн	Үндэсний зөвлөлд магадлан итгэмжлүүлэх хүсэлт тавьж, магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн сургууль нь дэд гишүүнээр элсэнэ.	800000,0 төгрөг
5	Ажиглагч гишүүн	Үндэсний зөвлөлд магадлан итгэмжүүлэх хүсэлт тавихаар бэлтгэж буй сургууль ажиглагч гишүүнээр элсэнэ.	500000,0 төгрөг

Хоёр. Гишүүн хувь хүн

д.д	Гишүүний төрөл		Хураамж
1	Зөвлөх гишүүн	Монгол улсын боловсролын салбарын тодорхойлогч, Үндэсний зөвлөлийн гишүүн, Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн комиссын гишүүн, Мэргэжлийн боловсролын магадлан итгэмжлэлийн комиссын гишүүн, Мэргэжлийн зөвлөлийн гишүүн, Ажлын албаны ажилтнууд нь зөвлөх гишүүнээр шууд бүртгэгдэнэ.	50000,0 төгрөг
2	Шинжээч гишүүн	Үндэсний зөвлөлөөс эрх олгогдсон шинжээч нь шинжээч гишүүнээр шууд бүртгэгдэнэ.	100000,0 төгрөг
3	Нэр дэвшигч гишүүн	Дотоод гадаадын судлаач, сургуулийн удирдах ажилтан, багш, оюутан, төгсөгч, ажил олгогч, мэргэжилтэн зэрэг боловсролын чанарын баталгаажууллын чиглэлээр хамтран ажиллах хувь хүн нь нэр дэвшигч гишүүнээр элсэнэ.	50000,0 төгрөг